

МЭРГЭЖИЛТЭН СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨР ХЯТАД – ХОНГКОНГ – МОНГОЛ - ТАЙВАНЬ

ТАНИЛЦУУЛГА

Мэргэжилтэн Солилцооны Хөтөлбөр (МСХ) нь БНХАУ/ Хонг Конг/ Тайван/ Монгол Улс дахь төрийн бус байгууллагуудад ажиллаж буй мэргэжилтнүүдэд зориулсан солилцооны хөтөлбөр юм. Уг хөтөлбөрт хамрагдснаар Америкийн Нэгдсэн Улсын (АНУ) төрийн бус салбарын мэдлэг, туршлагаас суралцан, дадлага хийх боломжтой.

Хөтөлбөр эхлэхээс өмнө шалгарсан оролцогчид цахим бэлтгэл сургалтад хамрагдаж Бээжин /Хонг Конг /Улаанбаатар/ Тайпэй хотод зохиогдох нэг өдрийн хөтөлбөрийн танилцуулга үйл ажиллагаанд оролцоно. Хөтөлбөрийн танилцуулга үйл ажиллагааны дараа АНУ-ын Вашингтон хот руу зорчин, нээлтийн үйл ажиллагаанд оролцон, хөтөлбөрийн үндсэн хэсэг болох дөрвөн долоо хоногийн дадлагын ажлыг холбогдох байгууллагад эхлүүлнэ.

Хөтөлбөрийн оролцогч нь дадлагын үеэр хөтөлбөрийн түнш байгууллагын ажилтанд дагалдах, хурал уулзалтад суух зэргээр өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох бөгөөд дадлагын төгсгөлд 2 өдрийн хаалтын үйл ажиллагаа болон хөтөлбөрийн бусад оролцогчидтой Мэргэжилтэн Солилцооны Хөтөлбөрийн хуралд оролцох болно. Оролцогчид эх орондоо ирсний дараа өөрийн боловсруулсан төслийг бие даан хэрэгжүүлэх шаардлагатай. Түүнчлэн 2024 – 2025 онд АНУ-д хүлээж авсан түнш байгууллагын ажилтнууд БНХАУ/Хонг Конг/ Тайван/ Монгол Улсад зочилж туршлага солилцсоноор энэ жилийн хөтөлбөр өндөрлөнө.

Хөтөлбөрийн оролцогч бүр өөрийн бие даасан төслийг хэрэгжүүлэх шаардлагатай ба төслөө хөтөлбөрийн туршид сурсан зүйлс дээрээ үндэслэн боловсруулна. Уг төслийг заасан хугацаанд багтаан хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд олон хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой. Үүнд: судалгааны ажил, өөрийн ажиллаж буй байгууллагадаа шинэ төсөл/хөтөлбөр санаачлах, ажил гүйцэтгэх шинэ арга барил нэвтрүүлэх, цуврал лекц зохион байгуулах зэрэг өөрийн ажлын онцлогт зохицсон хэрэгцээтэй төсөл хэрэгжүүлж болно. Төслийн санал тухайн орны нөхцөл байдалд нийцсэн, шинэлэг, нийгэмд хэрэгтэй байхыг чухалчилна. Өргөдөл гаргахдаа төслийн санааг дэлгэрэнгүй, тодорхой бичиж ирүүлэх шаардлагатай.

Намар болон хавар зохион байгуулагдах хөтөлбөрийн 2 бүлэгт нэгэн зэрэг өргөдлийн маягт хүлээн авна. Хөтөлбөрийн эхний бүлэг 2023 оны намар АНУ руу явах бөгөөд (улаан өнгөөр тэмдэглэгдсэн цагийн хуваарийн дагуу оролцоно) дараагийн бүлэг 2024 оны хавар (цэнхэр өнгөөр тэмдэглэгдсэн цагийн хуваарийн дагуу) АНУ дахь солилцоонд оролцоно. Хөтөлбөрт өргөдлөө илгээхдээ намар эсвэл хаврын хөтөлбөрийн аль нэгийг сонгох юм уу эсвэл намар, хаврын аль ч цагийн хуваариар оролцох боломжтой эсэхээ урьдчилан мэдэгдэх шаардлагатай.

ХӨТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

6 сар-8 сар, 2023 | 2 сар-4 сар, 2024

Цахим уулзалт

- Мэргэжлийн чадвар сайжруулах воркшоп
- Багаар ажиллах арга хэмжээ

9-р сарын 5 | 5-р сарын 6

Хөтөлбөрийн танилцуулга

- Хөтөлбөрөөс хүлээх хүлээлт
- Аяллын логистик мэдээлэл

9-р сарын 6-9 | 5-р сарын 8-11

Хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаа, Вашингтон хот

- АНУ-ын төрийн бус салбарын танилцуулга
- Хөтөлбөрийн нээлт
- Багаар ажиллах арга хэмжээ

9-р сарын 11 - 10-р сарын 6 | 5-р сарын 13 - 6-р сарын 7

Дадлага ажлын хуваарилалт

- АНУ-ын төрийн бус байгууллагын үйл ажиллагаанаас суралцан, Америк хамт олонтой туршлага хуваалцаж, мэдээлэл солилцоно
- 2 өдрийн төгсөлтийн үйл ажиллагаа болон хөтөлбөрийн үнэлгээ

10-р сарын 9-13 | 6-р сарын 10-14

Мэргэжилтэн Солилцооны Хөтөлбөрийн Хурал

- Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн манлайлагчидтай хамт Вашингтон Дисид зохиогдох хуралд оролцох

Бие даасан төсөл

- Солилцооны хөтөлбөр дууссаны дараа туршлага дээрээ үндэслэн бие даан төсөл хэрэгжүүлэх

Анхааруулга: Мэргэжилтэн Солилцооны хөтөлбөрийн АНУ-д хийх дадлага нь тухайн улсуудын аяллын нөхцөл байдал дээр тулгуурладаг. Олон улсын аялал хийхийг хориглосон, эсвэл бусад нөхцөл байдлаас шалтгаалан хувь хүн болон байгууллага, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулах нөхцөл байдал үүсвэл хөтөлбөрийн аяллын хэсэг хойшлох, эсвэл цахим хэлбэрт шилжих магадлалтай. Энэхүү шийдвэр нь тухайн улс болон нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн бодлого зохицуулалтад нийцүүлж шийдвэрлэгдэнэ.

Хөтөлбөрт оролцогчдод тавигдах шаардлага:

- **Байгаль орчин, халамж, хууль зүйн зөвлөгөө, нийгмийн хөгжлийн чиглэлээр төрийн бус байгууллагад ажиллаж буй 25-40 насны мэргэжилтэн байх.** Бусад салбарт амжилттай ажиллаж буй өргөдөл гаргагчдын хүсэлтийг мөн харгалзан үзнэ. Төрийн албан хаагч болон эрдэм шинжилгээний байгууллагын ажилчдын материалыг хүлээн авах тоо хязгаартай.
- **Англи хэлний бичгийн болон ярианы зохих мэдлэгтэй байх** (АНУ-д бие даан ажиллаж, амьдрах чадвартай)
- **Хөтөлбөрийн төгсгөлд эх орондоо буцаж ирсний дараа төсөл хэрэгжүүлэх чин хүсэлтэй байх**
- **Мэргэжлийн өндөр ур чадвартай байх**
- **Бие даан 5-6 долоо хоногийн дадлага ажлыг гүйцэтгэх чадвартай байх**
- **АНУ-д удаан хугацаагаар ажиллаж, амьдраагүй байх**

АНУ- БНХАУ Харилцааг Эрхэлсэн Үндэсний Хороо хөтөлбөрт оролцогчдын виз авах, аялах болон түр оршин суух байрны асуудлуудыг шийдэхэд хамтран ажиллана. Хөтөлбөрийн турш оролцогчид айлд байрлах хэлбэрээр АНУ-д байрлана. Хөтөлбөрт хамрагдах бүх зардлыг хөтөлбөр зохион байгуулагч хариуцна.

Хөтөлбөрийн өргөдөл хүлээн авах эцсийн хугацаа: 2023 оны 6-р сарын 12.

УГ ХӨТӨЛБӨРИЙГ АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР АНУ-БНХАУ ХАРИЛЦААГ ЭРХЭЛСЭН ҮНДЭСНИЙ КОМИСС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.